



# ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын дотоод үнэт цаас гэдэг нь хөрөнгийн зах зээл дээрх төгрөгийн бондын суурь хүү буюу өгөөжийн муруйг тогтоодог, хөрөнгө оруулагчдын хувьд эрсдэлгүй, хөrvөх чадвар сайтай санхүүгийн хэрэгсэл юм.



## ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ:

Засгийн газрын дотоод үнэт цаас гаргах, арилжаалахтай холбоотой харилцааг **“Өрийн удирдлагын тухай хууль”**-д заасны дагуу зохицуулна.



## ЗОРИУЛАЛТ:

**Өрийн Удирдлагын Хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу:**


**12.1.3. ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ ДЭМЖИХ;**



## ДАВУУ ТАЛ:



Хүүгийн орлогын татваргүй



Хөrvөх чадвартай



Эрсдэлгүй



Тендерийн баталгаа



## АЧ ХОЛБОГДОЛ:

**1** Дотоодын **зах зээлийг дэмжих** хөрөнгө оруулагчдад **эрсдэлгүй**, хөrvөх чадвар сайтай **санхүүгийн хэрэгсэл** санал болгодог.

**2** Хөрөнгийн зах зээлд эрсдэлгүй **жишиг хүү тогтоох** буюу **өгөөжийн муруйг** бүрдүүлдэг.

**3** Төгрөгийн **суурь хүүг** тогтоосноор **гадаадын хөрөнгө оруулагчдыг** дотоодын хөрөнгийн зах зээлд оролцох **сонирхлыг** нэмэгдүүлдэг.



## АРИЛЖААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:



Үнэт цаас гаргагч



www.mof.gov.mn

САНГИЙН ЯАМ



Анхдагч арилжааны цахим систем



www.bond.mse.mn

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Хөрөнгө оруулагч



Арилжаанд оролцохдоо **“Брокероор”** дамжина



Арилжааны хугацаа



**2 долоо хоногт нэг удаа**  
/Лхагва гараг бүр/  
Цаг: 10:00- 11:00 цаг



Төлбөр тооцооны горим



**T+0** буюу та үнэт цаас авах мөнгөн хөрөнгөө **урьдчилан** байршуулсан байна.



# ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?

1

Та Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд оролцохын тулд дурын брокерын компанийг сонгон **үйлчлүүлнэ**

Иргэн ААН



2

Хэрэв та үнэт цаасны **дансгүй** бол брокерын компаниар дамжуулан, үнэт цаасны **данс нээлгэх** хүсэлтээ гаргана

3

Та өөрийн сонгосон **брокерын компанийн** цахим систем, утасны апллийшн зэргээр **дамжуулан** үнэт цаасны анхдагч зах зээлийн **арилжаанд оролцоно**



[www.bond.mse.mn](http://www.bond.mse.mn)



4

Та өөрийн арилжааны **дансанд** үнэт цаас авах мөнгөн хөрөнгийг **урьдчилан байршуулна**

5

Та хэдэн **ширхэг**, ямар өгөөжийн хувтай **үнэт цаас** авах **саналаа брокерын** цахим системээр дамжуулан **өгнө**

6

**Брокерын компаниас** таны үнэт цаас авсан эсэх мэдээллийг арилжаа дууссаны дараа танд мэдэгдэх болно



САНГИЙН ЯАМ



ҮЦТХТ

7

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв таны авсан үнэт цаасыг таны нэр дээрх үнэт цаасны хадгаламжийн дансанд хадгална




8

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс таны **үнэт цаас авсан дүн** болон **брокерын үйлчилгээний хөлсийг** хасан тооцож үлдсэн мөнгийг таны **цахим хүсэлтийн** дагуу **буцаан шилжүүлнэ**

9

Та авсан **үнэт цаасаа** Монголын хөрөнгийн биржийн цахим системээр дамжуулан **хоёрдогч зах зээлд** арилжаалах боломжтой



**Анхаарах!!!** Зохицуулагч байгууллагуудаас Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагчийн арилжаанаас шимтгэл **авдаггүй**, харин **Брокерын** компани шимтгэл авах бөгөөд таны сонгосон компаниас хамаарч **шимтгэлийн хувь** хэмжээ **өөр өөр** байхыг **анхаарна уу**.



## ҮНЭТ ЦААСНЫ ҮНДСЭН БОЛОН ХҮҮГИЙН ТӨЛБӨРӨӨ ХЭРХЭН АВАХ ВЭ?



Таны эзэмшиж буй үнэт цаасны **үндсэн** болон **хүүгийн** төлбөрийг хуваарийн дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд байршуулах бөгөөд та өөрийн нэр дээрх банкны данс руу цахимаар хүсэлт гарган шилжүүлэн авна.

Монгол Улсын Сангийн яам

2025

# ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ЗАРЧИМ



## ҮНЭТ ЦААСНЫ ТӨРӨЛ:

/Өрийн удирдлагын тухай хууль 27.1 заалт/

### Богино хугацаат (1 жил хүртэл)

**Хямдруулалттай**

Хөрөнгө оруулагчаас  
санал болгосон  
өгөөжийн хувиар  
үнэт цаасыг  
хямдруулан авна.  
Хугацааны эцэст үнэт  
цаас нэрлэсэн  
үнээрээ төлөгднө.

### Дунд хугацаат (1-5 жил)



**Урьдчилан  
зарласан**

Үнэт цаас  
гаргагчаас купоны  
хувийг урьдчилан  
зарлана.

### Урт хугацаат (5 жил дээш)



**Купонтой**

**Өрсөлдөөнтөөр  
тогтох**

Хөрөнгө оруулагчид  
өгөөжөөр өрсөлдөж,  
биелсэн саналын  
жигнэсэн дунджаар  
купоны хувь тогтоно.

## ҮНЭТ ЦААСНЫ ХЭЛБЭР:

**Та** Засгийн газрын дотоод үнэт цаас авах саналаа  
**өрсөлдөөнт** болон **өрсөлдөөнт бус** хэлбэрээр өгөх  
боломжтой.

### Өрсөлдөөнт санал

Авах үнэт цаасны өгөөж,  
тоо ширхгийн саналыг  
өгнө. Та өөрийн санал  
болгосон өгөөжөөр үнэт  
цаас авна.



### Өрсөлдөөнт бус санал

Авах үнэт цаасны тоо  
ширхгийн саналыг өгнө.  
Та өрсөлдөөнт санал дээр  
тогтсон хүүгээр үнэт цаас  
авна.

**70%-100%**

**Нийт зарласан дүн**

**30%**



## ХУВААРИЛАЛТЫН ЗАРЧИМ:

### Өрсөлдөөнт бус санал:

- **30%-с бага** санал ирсэн тохиолдолд шууд хуваарилна.
- **30%-с их** санал ирсэн тохиолдолд хувь тэнцүүлэн хуваарилна.

### Өрсөлдөөнт санал:

- Өрсөлдөөнт бус саналыг эхэнд хуваарилах бөгөөд тус саналаас хамаарч өрсөлдөөнт саналыг 70%-аас 100% хүртэл хуваарилах боломжтой.

### Нэг хөрөнгө оруулагчид хуваарилах хязгаар:



- ЗГДҮЦ-ны зах зээлийг дэмжих зорилгоор  
гаргасан үнэт цаасны хувьд арилжаалахаар  
зарласан дүнгийн:

**25%**

- Бусад зорилгоор гаргасан үнэт цаасны хувьд  
арилжаалахаар зарласан дүнгийн:

**50%**

**Анхаарах:** Нэг хөрөнгө оруулагч илүү санал өгч болох бөгөөд хэрэв нийт ирүүлсэн санал зарласан хэмжээнд хүрээгүй тохиолдолд дээрх хязгаарыг өрсөлдөөнт болон өрсөлдөөнт бус санал дээр нэмэгдүүлж болно.

